**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 02 өдөр Дугаар А/58 Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2018 оны А/318 тушаал "Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын журам", Батлан хамгаалахын сайдын 2021 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэвсэгт хүчний 100 жилийн ойд зориулсан "Монгол улсын Зэвсэгт хүчин-100" гар зургийн уралдаан, "Эрхмийн дээд Монгол эр хүн" сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг аймаг, сумдын ерөнхий боловсролын сургууль коллежийн оюутнуудын дунд 2021 оны 1 дүгээр сарын 20-оос 2021 оны 2 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Уралдаан зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар батлсугай.

3. Уралдааныг "Ковид-19" цар тахалын халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, удирдамжийн дагуу явуулж, нэгдсэн дүнг танилцуулахыг Цэргийн штабын дарга /хурандаа Н.Хүрэлээ/-д үүрэг болгосугай.

4. Уралдаанд шаардлагатай 753.000 /долоон зургаан тавин гурван мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал, урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ

231010182

Аймгийн Засаг даргын 2021 оны
..02.. дугаар сарын..02..өдрийн ..А/58..
дугаар захирамжийн хавсралт

# ТЭМЦЭЭН УРАЛДААНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Арга хэмжээ | | Төсөв | Хянасан |
|---|---|---|---|---|
| 1 | Эссэ бичлэг | 1-р байр | 100000 | |
| 2 | | 2-р байр | 80000 | |
| 3 | | 3-р байр | 60000 | |
| 4 | | Тусгай байр | 20000 | |
| 5 | Гар зураг | 1-р байр | 180000 | |
| 6 | | 2-р байр | 155000 | |
| 7 | | 3-р байр | 130000 | |
| 8 | | Тусгай байр-10 хүн | Талархалын хуудас | |
| 9 | Гэрэл зургийн өнгөт цаас | | 28000 | |
| **Нийт** | | | 753000 | |